

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ

АУДИТЫН КОД: СЭА-2021/02-ШТА-ГА

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮНГЭЭС



Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд барилга угсралт, их засвар зэрэг бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг бус машин, тоног төхөөрөмж худалдан авах төсөл арга хэмжээг түлхүү байдлаар тусгаж байгаа нь хөрөнгө оруулалтын мөн чанар, үр өгөөжийг бууруулж байна.



“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

АГУУЛГА

1. Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалт
2. Аудитын Ерөнхий дүн
3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтай шинээр эхлэх болон шилжих төсөл, арга хэмжээний төлөвлөлт
4. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтай төслүүд төлөвлөлтийн шаардлага хангасан эсэх талаарх дүгнэлт
5. Худалдан авах ажиллагаа
6. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл
7. Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтад тусгагдсан боловч хэрэгжээгүй төслүүд
8. Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтад тусгагдсан ч хэрэгжээгүй төсөл, арга хэмжээ (тоо, байршлаар)
9. Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтад тусгагдаж дутуу хэрэгжсэн төсөл, арга хэмжээний судалгаа
10. Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтад тусгагдаж дутуу хэрэгжсэн төсөл, арга хэмжээ (тоо, байршлаар)
11. Хөрөнгө оруулалтын төсвийн хяналт
12. Аудитын зөвлөмж

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Хаяг Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум VI баг,
Аймгийн ЗДТГ-ын өргөтгөлийн 2 давхар
Утас: 7036-2442, 7036-3047, 7036-3040,
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn



“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ



Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтыг өмнөх онтой харьцуулахад төсөл, арга хэмжээний тоо 2 дахин, санхүүжих дүн 1,952.3 сая төгрөгөөр нэмэгдэж 4,173.0 сая төгрөгийн 98 төсөл, арга хэмжээ батлагджээ.

АЙМАГ, СУМДЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАЖ БАТАЛСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ


Төсөл, арга хэмжээний санхүүжлтийн эх үүсвэр /сая төгрөгөөр/



Төсөл, арга хэмжээ /тоогоор/



2020 онд хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээний төрөл



Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд авто замын 23 төсөл, арга хэмжээнд 1,314.3 сая төгрөг, барилга байгууламжийн 6 төсөл, арга хэмжээнд 268.2 сая төгрөг, их засварын 19 төсөл, арга хэмжээнд 696.5 сая төгрөг, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авах 35 төсөл, арга хэмжээнд 1,011.3 сая төгрөг, бусад 10 төсөл, арга хэмжээнд 268.2 сая төгрөг, зураг төсөв хийлгэх 5 төсөл, арга хэмжээнд 133.7 сая төгрөг, нийт 98 төсөл, арга хэмжээнд 4,173.0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталсан байна.



“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮН



Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитаар аймгийн хэмжээнд нийт 2,816.3 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ

Тоо: 72



Мөнгөн дүн:
2,816.3 сая
төгрөг



ГОЛ ЗӨРЧИЛ



Шинээр эхлүүлэх 92 төсөл арга хэмжээний 37-г нь буюу 40.2 хувийг хуулийн шаардлага хангаагүй байхад баталсан.



Худалдан авах ажиллагааны 62.3 хувийг цахим системээр зохион байгуулаагүй.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ

-Хэрэгжээгүй 29 төсөл, арга хэмжээ

-Хэрэгжилт дутуу: 9 төсөл, арга хэмжээ

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2020 ОНД АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ



Төрийн үйлчилгээний 2 барилга



Гудамж талбайн гэрэлтүүлгийн 2 төсөл, арга хэмжээ



600 метр хатуу хучилттай автозам, 1350 м² авто зогсоол



Нийтийн эзэмшлийн талбайн тохижилтын 4 төсөл, арга хэмжээ



11 байршилд замын засвар, тэмдэг тэмдэглэгээ



Барилгын гадна дотор засварын 5 төсөл, арга хэмжээ



Байгууллагуудын албан хэрэгцээнд аймгийн ЗДТГ-1, 5 суманд 6 автомашин



Дулааны шугам сүлжээ, өргөтгөлийн 4 төсөл, арга хэмжээ



Тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авах 20 төсөл, арга хэмжээ



Зураг төсөв хийлгэх 2 төсөл, арга хэмжээ



“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ

2020 ОНД ТӨСВИЙН
ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТААР
САНХҮҮЖҮҮЛЭХ

98

төсөл, арга
хэмжээ

93.9%

Шинээр
хэрэгжих

Төслийн тоо: **92**
Төсөвт өртөг: **3,284.1** сая төгрөг

6.1%

Өмнөх
оноос
шилжиж
ирсэн

Төслийн тоо: **6**
Төсөвт өртөг: **888.9** сая төгрөг

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ ТӨСЛҮҮД ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГАСАН ЭСЭХ ТАЛААРХ ДҮГНЭЛТ



40.2%

2020 онд шинээр эхлүүлэхээр баталсан 92 төсөл арга хэмжээний 37 нь буюу **40.2 хувь** нь хуулийн шаардлага хангаагүй байна.



Тооцоо судалгааг урьдчилан хийгээгүй, зураг төсөвгүй, зураг төсөвт магадлал хийлгээгүй зэрэг төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.



“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

Шинээр хэрэгжих 92 төсөл, арга хэмжээнээс 61 төсөл, арга хэмжээнд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга

14.7%

Нээлттэй тендер шалгаруулалт

47.5%

Харьцуулалт

36.2%

Шууд гэрээ байгуулах арга

1.6%

Зөвлөх үйлчилгээ




ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ СИСТЕМИЙН АШИГЛАЛТ


37.7%

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны цахим систем ашиглалт 37.7 хувьтай байна

Төсөл, арга хэмжээний санхүүжилт (сая төгрөг)



Төсөл, арга хэмжээ (тоогоор)



Тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтод заасан шалгуур үзүүлэлтийг хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

Үнэлгээний хороо болон ажлын хэсэгт томилогдсон гишүүнээс 26 нь ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргаж, гарын үсгээр баталгаажуулаагүй байна.



“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ



Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжүүлэх 98 төсөл, арга хэмжээний 60 нь бүрэн, 9 нь дутуу хэрэгжсэн бол 29 нь огт хэрэгжээгүй бөгөөд 61.2 хувийн бодит гүйцэтгэлтэй байна.



61.2%

ГҮЙЦЭТГЭЛ (Төсвийн захирагчдаар)

Төсвийн захирагчийн байршил	Батлагдсан төсөл арга хэмжээний тоо	Гүйцэтгэлийн хувь
Ерөө сум	19	10.5
Аймгийн Засаг дарга	24	45.8
Сайхан сум	3	66.7
Сүхбаатар сум	10	70.0
Мандал сум	12	75.0
Замын сан	17	76.5
Шаамар сум	5	100.0
Цагааннуур сум	3	100.0
Орхон сум	2	100.0
Баянгол сум	2	100.0
Баруунбүрэн сум	1	100.0
Нийт төсөл арга хэмжээний тоо	98	



Аймаг болон 4 сумын хөрөнгө оруулалт, аймгийн Замын сангаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний бодит гүйцэтгэл 77.0-оос доош хувьтай байна.



“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

2020 ОНЫ ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД ТУСГАГДСАН БОЛОВЧ ХЭРЭГЖЭЭГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт **98** төсөл, арга хэмжээний **29.6 хувь** нь огт хэрэгжээгүй байна.



ХЭРЭГЖЭЭГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

НИЙТ 29 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ	НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ 1,565.2 сая төгрөг	САНХҮҮЖИХ ДҮН 1,465.2 сая төгрөг
--------------------------------------	--	--

ОГТ ХЭРЭГЖЭЭГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ШАЛТГААН

58.6%	Ковид-19 цар тахлын улмаас хөдөлгөөний хязгаарлалт хийгдсэн.
24.1%	Зураг төсөв, тооцоо судалгаа хийгдээгүй учраас худалдан авах ажиллагаа зарлах боломжгүй болсон.
17.3%	Тендер шалгаруултад оролцогчийн санал ирээгүй.

2020 ОНЫ ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД ТУСГАГДСАН БОЛОВЧ ХЭРЭГЖЭЭГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ (тоо, байршлаар)

Сүхбаатар-3  Аймаг-8, замын сан-1

29

Ерөө-14

Сайхан-1

Мандал-2



Төлөвлөсөн боловч огт хэрэгжээгүй төсөл, арга хэмжээний дийлэнх буюу **48.3 хувь** нь Ерөө суманд ногдож байна.



“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

ДУТУУ ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт **98** төсөл, арга хэмжээний **9.2 хувь** нь буюу 9 нь дутуу хэрэгжсэн байна.



ДУТУУ ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

ТӨСӨЛ,
АРГА ХЭМЖЭЭ

9

НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ

370.0 сая төгрөг

ТАЙЛАНТ ОНД
САНХҮҮЖИХ ДҮН

370.0 сая төгрөг

ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ ДУТУУ ХЭРЭГЖСЭН ШАЛТГААН

33.3%

Гэрээ байгуулсан боловч Ковид-19 цар тахлын улмаас төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжээгүй байна.

66.7%

Гүйцэтгэгч ажлаа дуусгасан боловч Ковид-19 цар тахлын улмаас улсын комисс ажиллаагүй байна.

ДУТУУ ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТОО, БАЙРШИЛ



Дутуу хэрэгжсэн төсөл, арга хэмжээний 55.6 хувийг аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ эзэлж байна.



“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ

Орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилтэд төсвийн ерөнхийлөн захирагчийн зүгээс тавих дотоод хяналт хангалтгүй байна.

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ДОТООД ХЯНАЛТ

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналт болох Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2020 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, гүйцэтгэлийн байдалд хяналт шалгалт хийж, үнэлэлт дүгнэлт өгөөгүй байна.

Сүүлийн 3 жилд хийсэн аудитын дүнгээс харахад тус алба нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилтэд, хяналт, шалгалт огт хийгээгүй, үр дүнг үнэлээгүй байна.

ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

ТӨСӨЛ,
АРГА ХЭМЖЭЭ
69

Орон нутгийн төсвийн хөрөнгө
оруулалтаар хэрэгжүүлсэн 53
төсөл, арга хэмжээ

Замын сангийн хөрөнгө
оруулалтаар хэрэгжүүлсэн 16
төсөл, арга хэмжээ

НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ
2,607.8.0 сая төгрөг





“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ



Сэлэнгэ аймгийн Засаг дарга
Ш.Оргил-д:

- Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, урт болон дунд хугацааны төлөвлөгөө боловсруулж мөрдөх.
- Эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлоор нь эрэмбэлсэн, төлөвлөлтийн шаардлага хангасан төсөл арга хэмжээг төлөвлөгөөнд тусгуулахаар өргөн мэдүүлэх.
- Хөрөнгө оруулалтын төсвийг хэт жижиглэсэн болон тоног төхөөрөмж, машин техник худалдан авах төсөл, арга хэмжээнд бус бүтээн байгуулалтын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн, үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх.
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төсвийн тодотгол хийхгүй байх.
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилтэд дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх.
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн үр дүнг үнэлж, үнэлэлт дүгнэлт өгч байх



Орон нутгийн өмчийн газрын
дарга П.Эрдэнэсайхан-д:

- Аймаг, сумдын худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг үнэн зөв нэгтгэн, хүргүүлж байх.
- Тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтод заасан шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан гүйцэтгэчийг сонгон шалгаруулж байх.

Аймгийн ЗДТГ-ын дарга Ө.Сувдаа-д:

- “Үнэлгээний хороо”, “Ажлын хэсэг”-т ажиллах гишүүдийн “Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг”, “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг бүрэн гаргуулж, гарын үсгээр баталгаажуулж байх.
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаж, дутуу хэрэгжсэн төсөл, арга хэмжээг бүрэн гүйцэтгүүлж, ашиглалтад оруулах.